



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/116

Хэрлэн сум

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 313 дугаартай "Дүрэм батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Адарга сумын нутаг дэвсгэрт байрлах Дунд булаг нэртэй MV-012960 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Талст орчлон" ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг мөрдөж, стандартын дагуу тэсэлгээний хэрэгслийг хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг "Талст орчлон" ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Д.Баярхүү), Баян-Адарга сумын Засаг дарга (О.Лхагвадорж) нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (Д.Батхүү)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010323

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 08 өдрийн
АИЖ захирамжийн хавсралт

“Талст орчлон” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис,
тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын
байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	48	33	31.77	111	11	49.45
2	48	33	28.74	111	11	50.22
3	48	33	28.24	111	11	45.17
4	48	33	31.26	111	11	44.36